



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/21

Мандалговь

Онцгой байдлын газрын сургалтын танхимын
засварын ажлын гүйцэтгэгчийг сонгох
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сургалтын танхимын засварын /Онцгой байдлын газар/ ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Т.Төрбат (Иргэний төлөөлөл)

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Б.Батхүү (Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Төвшинжаргал (Онцгой байдлын газрын нягтлан бодогч)

Хоёр. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (М.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Төвшинжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060082